## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 1 | **Зорилго: Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох** | | | | | | |
| | **Зорилт:1 Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж мөрдөх, чанарын хяналтын үйл ажиллагааг холбогдох дүрэм журамд нийцүүлэн хэрэгжүүлэх.** | | | | | | |
| **1.1** | ***Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох*** | | 1.1.1 Мэргэжлийн боловсрол сургалтын орон нутгийн салбар зөвлөл, сургуулийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | Салбар зөвлөлийн хурал 2 удаа, Удирдах зөвлөлийн хурал 1 удаа зохион байгуулсан. | Хуралдсан тоо: 3<br><br>Шийдвэрлэсэн асуудал: 5 | 2024 оны эхний хагас жилийн байдлаар Орон нутгийн салбар зөвлөл нэг удаа, Сургуулийн Удирдах зөвлөл нэг удаа тус тус хуралдсан. Сургуулийн Удирдах зөвлөлийг томилсон дээд байгууллагын шийдвэр удтал хүлээгдсэнээс Удирдах зөвлөлийн хурал төлөвлөсөн тоонд хүрээгүй. МБС-ын Орон нутгийн салбар зөвлөлөөр 2024-2025 онд элсүүлэх 20 мэргэжлээр 515 оюутан элсүүлэхээр шийдвэр гаргуулж, холбогдох газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. Мөн сургуулийн удирдах зөвлөлөөр 2024 оны төсвийг хэлэлцүүлж, хуваарилалт хийлгэсний дээр удирдах зөвлөлийн тэргүүн сонгох, Стратеги төлөвлөгөөний (2021-2025) | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийн байдал дээр үнэлгээ авсан. | |
| | | | 1.1.2 Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэнд дүгнэлт хийж /2021-2025/үйл ажиллагааг шинэчлэгдсэн дүрэм журамд нийцүүлэн, төлөвлөгөөнд тодотгол хийнэ. | 5 дүрэм, 21 журам, 4 хөтөлбөр, 19 зөвлөл, баг, ажлын хэсгийг шинэчлэн баталж мөрдсөн. | Дүрэм журмын тоо: 3-аас дээш хэвлэн гаргасан эмхэтгэл | Сургуулийн Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал дээр дүн шинжилгээ хийж УЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгол хийх зөвлөн туслах баг, ажлын хэсгийг сургуулийн захирлын 2024 оны А/17 тоот тушаалаар баталгаажуулан ажиллаж байна. | 50% |
| | | | 1.1.3 Элсэлтийг хяналтын тоонд тулгуурлан зохион байгуулж, элсэлт, сургалт, төгсөлт, ажил эрхлэлтийн мэдээллийг холбогдох байгууллагад гаргаж өгнө | 2023-2024 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсролын 1 жилийн болон 2.5 жилийн ангийн 13 мэргэжлээр нийт 337 оюутан элсэн суралцсан бөгөөд техникийн боловсролын 3 мэргэжлийн 60 суралцагч 2022-2023 оны хичээлийн жилийн 2-р улирлаас элсэн суралцсан. | Эрэлттэй байгаа шинэ мэргэжлийн саналын материалыг хуулийн хугацаанд бүрдүүлэн хүргүүлж, шийдвэрлүүлнэ. | Эхний хагас жилийн байдлаар 7 мэргэжлийн 130 оюутан мэргэжлийн боловсрол эзэмшиж, төгсөлт хийсэн. Үүнээс төгсөгчдийн мөшгих судалгаагаар 56% нь байнгын болон түр ажлын байранд зуучлагдан хөдөлмөр эрхэлж, 15% нь ТБОС-д хамрагдсан судалгаатай байна. | 75% |
| | | | 1.1.4 Орон нутгийн хөгжлийн чиг хандлага, шаардлагатай ажлын байрны мэдээлэлд шинжилгээ хийх | Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн 2021-2023 оны төлөв байдлын судалгааны тайлан хамтран гаргасан. | Судалгааны тайлан шинэчлэн гаргах ажлыг эхлүүлэх хэрэгжилтийн хувь: 100% | 2024 оныг “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор энэ талын судалгааг ХХҮГ, орон нутгийн тэргүүлэх чиглэл болсон барилга, уул | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уурхайн түншлэгчидтэй (МАК, Цагаан суварга ХХК, Өргөн цемент шохойн үйлдвэр, Мандахын баяжуулах үйлдвэр) тогтоосон холбоогоор дамжуулж, шаардлагатай байгаа ажлын мэдээлэл авч шинэ хичээлийн элсэлтийн саналд тусгасан. | |
| 1.2 | ***Иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чанартай боловсрол, сургалтын үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах*** | | 1.2.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага, ажил мэргэжлийн стандарт, бүс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн шинэчилж, сургалтанд нэвтрүүлэх | Техникийн боловсролын 1.5 жилийн<br>-Барилгын техникч<br>-Автын механикч<br>-Цахилгааны техникч мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулж дүгнэлт гаргуулсан. | Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо: 1<br><br>Ажил олгогчийн сэтгэл ханамжийн хувь: 70-аас дээш хувь | Барилгын цахилгаанчин мэргэжлийн хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийлгэхээр зохих бэлтгэлийг хангаж байна. 2024 оны 01 дүгээр сарын сургуулийн захирлын А/21 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна. 2024 оны жилийн эцэст цаг хугацааны цагалбарын дагуу хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхээр төлөвлөж байна. | 50% |
| | | | 1.2.2 Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалт, мэргэжлийн түр сургалтыг зохион байгуулах | 2023-2024 оны хичээлийн жилд барилгын цахилгаанчин мэргэжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх бэлтгэл ажил хийгдсэн. | Суралцагчдын тоо: Элсэлтийн квот<br><br>Түр сургалтад хамрагдсан хүний тоо: Ажил олгогчийн хүсэлт | 2024 оны хагас жилээр ТБОС олгох 2 мэргэжлээр 16 оюутан амжилттай төгсч, дипломоо хамгаалсан. Тусгай зөвшөөрлийн хуулийн дагуу өөрийн бэлтгэж багаа мэргэжлийн чиглэлээр түр сургалт зохион явуулах нь нээлттэй хэдий ч зарим нэг дүрэм журмын нийцэлгүй байдалтай холбоотойгоор | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүлээлтийн байдалтай байна. | |
| | | | 1.2.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт үнэлгээний агуулга, арга зүйг шинэчлэн тусгах | Мэргэжлийн боловсрол олгох 2.5 жилийн сургалтын төгсөлтийн шалгалтад 7 мэргэжлийн үнэлгээний багц төлөвлөгөөг боловсруулж, баталгаажуулан төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан. | Шинэчилсэн үнэлгээний төлөвлөгөөний тоо:<br>- Техникч- 3<br>-Мэргэжлийн сургалт– 11<br>-Мэргэжлийн боловсрол- 7 | Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох 11 мэргэжлийн төгсөлтийн шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны А/128 тоот тушаал, Боловсролын Үнэлгээний төвийн захирлын 2024 оны А/39 дүгээр тушаал, 2023-2024 оны улсын шалгалтн удирдамжийг чиглэл болгон төгсөлтийг зохион байгуулсан. 11 мэргэжлээр 163 оюутан төгссөн. | 100 % |
| | | | 1.2.4 Төгсөгчдийн мэргэшлийн түвшинг баталгаажуулах хөндлөнгийн үнэлгээг зохион байгуулах, ажил олгогчийн төлөөлөл болон багш ажилтнуудаас дотоодын үнэлээч, баталгаажуулагчаар сургах | -2,5 жилийн төгсөлтийн үнэлгээнд нийт 7 бүлгийн 130 суралцагч хамрагдахаас 99.5% хамрагдсан.<br>- Үнэлээчээр 4 ажил олгогч оролцсон. | Үнэлгээний стандарт хангалтын хувь: 95-100% | Мэргэжлийн болон техникийн боловсролын 11 мэргэжлийн 163 суралцагч хамрагдсан төгсөгчдийн мэргэшлийн түвшинг баталгаажуулах хөндлөнгийн үнэлгээг зохион байгуулахад ажил олгогчийн төлөөлөл, хөндлөнгийн 6 үнэлээч оролцсон. БЕГ-ын нэг мэргэжилтэн төгсөлтийн үйл ажиллагааг хянаж ажилласан. | 90% |
| | | | 1.2.5 Ур чадварын зөрүү арилгах зорилгоор мэргэжлийн уралдаан зохион байгуулах | 7 мэргэжлээр сургуулийн захирлын нэрэмжит ур чадварын уралдаан.<br>Ерөнхий эрдмийн хичээлийн олимпиад- 5 | Мэргэжлийн ур чадварын уралдааны тоо: 7<br><br>Ерөнхий эрдмийн хичээлийн олимпиадын тоо: 5 | Жил бүрийн 4 дүгээр сарыг сургууль, мэргэжил сурталчлах сарын аян болгон зарладаг. Энэ удаагийн аянаар сургуулийн захирлын нэрэмжит Ур чадварын уралдаан 7 мэргэжлээр явагдаж нийт 126 хүүхэд оролцсоноос шилдэг 21 | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оюутан шалгарсан. Ерөнхий эрдмийн 2 мэргэжлээр Улсын уралдаанаас тэргүүн болон тусгай байрын шагнал хүртсэн. (Монгол хэл, математик) | |
| | | | 1.2.6 Чанарын баталгаажилт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ААН-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан, үйл ажиллагааг цагалбарлах | Менежментийн тогтолцооны баталгаажуулалт /ISO9001-2015 стандарт/ болон магадлах аудит хийх, гэрчилгээ эзэмшүүлэх тухай гэрээг "МОНСЕРТФ" ХХК-тай БГ-23/003 дугаарт гэрээгээр, зөвлөх үйлчилгээ үзүүлэх Просертф ХХК-тай хамтран ажиллах гэрээг мөн байгуулж зөвлөх үйлчилгээний сургалтаа авч түүний мөрөөр үйл ажиллагаандаа сайжруулалт хийснээр 2024 онд баталгаажуулат, аудит хийлгэх шат руу орохоор төлөвлөгдсөн. | ISO9001-2015 стандартыг хэрэгжүүлэгч батламжийг хүлээн авсан байна. | ISO 9001-2015 Менежмэнтийн тогтолцооны баталгаажуулалтын ажлын хэсэг үйл ажиллагааны цагалбарийн дагуу баталгаажуулалт хийлгэхээр бэлдэж байна. 2024 оны сүүлийн хагас жилд баталгаажуулат, аудит хийгдэхээр төлөвлөгдсөн. | 80% |
| | | | 1.2.7 Сургалтын сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг сайжруулах чиглэлээр ерөнхий эрдмийн болон мэрэгжлийн гарын авлага боловсруулж, тэнхимийн | Ерөнхий эрдмийн 3 хичээлийн гарын авлага, мэргэжлийн 4 гарын авлагыг сайжруулж, тэнхмээр хэлэлцүүлэн сургалтад ашиглаж байна. | Ерөнхий эрдмийн 5, мэргэжлийн 7 гарын авлага хэлэлцүүлж батлуулсан байна. | Ерөнхий эрдмийн 2, мэргэжлийн 4 гарын авлага хэлэлцүүлж, тус тусын тэнхимээр батлуулан сургалтанд ашиглаж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвлөлөөр хэлэлцүүлж, сургалтанд ашиглах | | | | |
| | | | 1.2.8 Номын сангийн үйлчилгээг сайжруулах, номын фондыг нэмэгдүүлэх | -‘’Бадрах Энержи’’ ХХК-ийн дэмжлэгээр номын фондыг 15 хувиар нэмэгдүүлсэн.<br>- 154 суралцагчид, багш, ажилтанд номын сангийн карт нээж ажилласан. | Номын фондыг 10%-аар нэмэгдүүлсэн байна.<br>- Ном ашиглалтыг 30-аас дээш хувиар нэмэгдүүлсэн байна. | Эхний хагас жилийн байдлаар 13 нэр төрлийн 72 ширхэг 13,583,300 төгрөгийн ном сурах бичгийн судалгааг хамтран ажиллагч Бадрах Энержи ХХК-ийн хүсэлтээр хүргүүлсэн. Шинэ хичээлийн жилд номын фондыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллаж дээрх ном, сурах бичгийг нийлүүлэхээ илэрхийлсэн. | 90% |
| 1.3. | ***Элсэлтийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн зохион байгуулж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийх*** | | 1.3.1 Бүс, орон нутгийн ХЗЗ-ийн эрэлтийг тодорхойлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн сүүлийн 5 жилийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж элсэлтийн хяналтын тооны саналыг боловсруулж, элсэлт зохион байгуулах | - 2023-2024 оны хичээлийн жилд нийт 560 суралцагч элсүүлэх элсэлтийн саналыг БСШУ-д хүргүүлсэн.<br>- Элсэлт 100 хувь бүрдсэн. | Элсэлтийн санал, хяналтын тоо:<br><br>Элсэлтийн хувь: 90-100% | 2023-2024 оны хичээлийн жилд 19 мэргэжлээр нийт 36 ангид 804 суралцагч элссэн ба 3 дугаар курсийн 7 ангийн 130 суралцагч, үүнээс мэргэжлийн боловсрол олгох сургалтанд 147 суралцагч, техникийн боловсрол олгох сургалтаар 16 суралцагч төгссөн. Энэ хичээлийн жилд төгсөлтийн шалтгалт болон дадлага ажил хийгдээгүй улмаас 98 суралцагч сургууль төгсөөгүй болно.<br>Нийгмийн түншлэлийн хувьд хамтарч ажилладаг байгууллагуудаас эрэлттэй ажлын байр, шаардлагатай байгаа ур чадварын судалгааг 02 дугаар сард хийснээр 03 дугаар сард дээд байгууллагат илгээх | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинэ хичээлийн жилийн элсэлтийн саналд тусган, шинээр уул уурхайн ашиглалт мэргэжлийн ангийн элсэлтийн санал хүргүүлсэн нь батлагдсан. Судалгааны ажилтан улирал тутам төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийж, дүгнэлтээ танилцуулдаг. Төгсөгчдийн 3.300 гаруй гишүүнтэй групп тогтмол ажиллаж шинээр зарлагдсан ажлын байрны мэдээллийг тогтмол оруулдаг. | |
| | | | 1.3.2 Шинээр элсэгч болон суралцагчийн давхардалгүй байдалд хяналт тавьж, цахим системд бүртгэх, баталгаажуулах | 2023-2024 оны хичээлийн жилд нийт 804 суралцагчийг TVETS.EDU.MN сайтын цахим бүртгэлд бүртгэсэн. Бүртгэл давхардаагүй. | Цахим статистик мэдээнд бүртгэсэн суралцагчийн тоо:<br><br>Бүртгэлийн хувь: 100% | Цахим статистик мэдээний сайт болох TVETS.EDU.MN-д 2023-2024 оны хичээлийн жилд 804 суралцагч бүртгэснээс эхний улиралд 178 төгсөгч хасагдаж, 626 суралцагч бүртгэлтэй үлдсэн. Эхний хагас жилийн байдлаар мэргэжлийн болон ТБОС-ын 163 төгсөгч хасагдана. | 95% |
| | | | 1.3.3 Төгсөгчдийн дүн, төгсөлтийн тушаалыг цахим хэлбэрээр архивлах, төгсөгчдийн мэдээллийг tvets.edu.mn мэдээллийн санд бүрэн оруулах | 2023 оны 1-р сард төгссөн МБС-ын 178 төгсөгчийн Б маягт, тушаалыг архивлаж, системээс хасалт хийлгэсэн. | Хэрэгжилтийн хувь: 100% | TVETS.EDU.MN-д 2024 оны 06 дугаар сарын 163 төгсөгчийн цахим мэдээлэл байршсан. | 100 % |
| | | | 1.3.4 Төгсөгчдийн мөшгих судалгааг хийх | 2023 онд төгсөгчдийн мөшгих судалгаанд 2.5, 1 жилийн 337 суралцагч хамрагдсан. Хувь:100 | Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн тоо:<br><br>Хамрагдалтын хувь: 85-100% | 2024 оны 06 дугаар сарын байдлаар төгсөгчдийн мөшгих судалгаанд 341 суралцагч хамрагдсанаас 116 нь ажлын байраар хангагдсан байна. Төмөр | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ажил эрхлэлтийн хувь: 45-аас дээш | замын 2 мэргэжлийн 19 суралцагч ажлын байранд уригдсан батламжаа хүлээн авсан байна. | |
| 1.4. | ***Нийгмийн түншлэлийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбооны оролцоог дэмжих, гадаад дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх*** | | 1.4.1 Төгсөгчдийг ажлын байранд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх | - 2022-2023 оны хичээлийн жилд 82 төгсөгч буюу 30,5 хувь нь ажилд зуучлагдсан.<br>- Нийт төгсөгчдийн 30 хувь нь шууд ажлын байртай болсон. | Хэрэгжүүлсэн ажлын тоо: 2<br><br>Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь:60-аас дээш %<br><br>Шууд ажлын байранд зуучлагдсан төгсөгчдийн хувь: 10-аас дээш | 2023-2024 оны хичээлийн жилд 3 жил суралцах 8 мэргэжлийн 9 ангид нийт 209 суралцагчид элсэн суралцаж, 2,5 жилийн Автомашины засварчин, Тогооч, Засал чимэглэлч, Гагнуурчин, Барилгын цахилгаанчин, Бэлэг дурсгалын зүйл урлаач, Хэвлэлийн график дизайнч мэргэжлээр 8 ангийн 130 суралцагчид төгссөн. Төгсөлтийн дараах ажил эрхлэлтийн тандалт судалгаагаар мэргэжлээрээ ажиллаж байгаа 29, эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа 19, цэргийн албанд 12, дараагийн түвшинд шатлан суралцаж байгаа 21, ЭЕШ өгөхөөр бэлтгэж буй 11 суралцагч байна. Мөн төмөр замын 5 мэргэжлээр 66 суралцагч сурч төгссөнөөс 45 нь шууд ажлын байранд урилга авч ажлын гараагаа эхлүүлээд байна. | 95% |
| | | | 1.4.2 Төгсөгчдийг гарааны бизнес эрхлэх чадварт сургаж, бизнесийн төсөл бичихэд дэмжлэг үзүүлэх | -Мэргэжлийн боловсролын 130 суралцагчдад бизнесийн төсөл бичих сургалтыг ХХҮГ-тай | Сургалтад хамрагдсан | Төгсөгчдийг гарааны бизнес эрхлэх чадварт сургаж, бизнесийн төсөл бичихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр сард Хөдөлмөр | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамтран зохион байгуулсан. - Мэргэжлийн 2 багш, 5 инженер хамрагдсан. | төгсөгчийн тоо: 100%<br><br>Боловсруулсан төслийн тоо: 3 | халамж үйлчилгээний газартай хамтран зохион байгуулсан сургалтад төгсөх курсийн 8 ангийн 250 суралцагч, Төмөр замын мэргэжлийн ангийн 15 суралцагчдыг хамруулլаа. | |
| | | | 1.4.3 Багш-инженер техникийн ажилтан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх | Мэргэжлийн 2 багш, 5 инженер хамрагдсан. | Хамрагдсан хүний тоо: Мэргэжлийн 5 багш, 7 инженер багш | Багш-инженер техникийн ажилтан солилцооны хөтөлбөрийн хүрээнд Төмөр замын Замчин мэргэжлийн зөвлөх инженер УБТЗ-ын замын мэргэжлийн багш Н.Алтанзагас, Дохиолол холбоо төвлөрүүлэлтийн инженер Б.Батпүрэв, УБТЗ-ын Сайншанд татах хэсгийн зааварлагч-машинч О.Мягмарсүрэн, Сайншанд татах хэсгийн машинч Д.Алтанбагана зэрэг инженер техникийн ажилтан нар мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байна. | 90% |
| | | | 1.4.4 Гадаад харилцааны хамрах хүрээ, үйл ажиллагааг өргөжүүлж, Япон улсын Монгол Ирээдүйн бахархал ТББ-тай хамтын ажиллагааны хүрээнд багш, ажилтнуудыг туршлага судлуулах | - Япон улсын Яманаши мужид зуны хөтөлбөрт 14 багшийг 2023 оны 7 дугаар сард 2 сарын хугацаагаар зохион явуулсан. | - 25-аас дээш багш, ажилтан хамруулах. | Япон улсын Монгол Ирээдүйн бахархал ТББ-тай хамтын ажиллагааны хүрээнд Япон Улсын Яманаши мужийн зуны хөтөлбөрт 10 багшийг 2 сарын хугацаагаар хамруулахаар гэрээ байгуулаад байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1.4.5 Мэргэжлийн холбоод болон мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, ШИЛДЭГ ТҮНШЛЭГЧ шалгаруулах арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулж түншлэгчидтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх | Шинээр 9 түншлэгчтэй хамтран ажилласан. | Шинээр 10-аас доошгүй түншлэгчтэй гэрээ байгуулсан байна. | Түншлэгч байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх, оюутан суралцагчдыг цалинтай дадлагажих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор Түншлэгч байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулж буй “Шилдэг түншлэгч” уралдаанд “Болор-аграмба” ХХК шалгарлаа. | 90% |
| | | | 1.4.6 Нийгмийн түншлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн дадлагыг ажил олгогч байгууллагуудтай хамтран зохион байгуулж, дадлагын сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах | - 2023-2024 оны хичээлийн жилийн эхний хагаст 2.5-ийн мэргэжлийн боловсрол, 1 жилийн нийт 369 оюутан – үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх үйлдвэрлэлийн дадлага хийсэн. | Дадлагад хамрагдалтын хувь: 100%<br><br>Дадлага хийлгэсэн ажил олгогчийн тоо: 109 | 2023-2024 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 388 аж ахуй нэгж, иргэнтэй үйлдвэрлэлийн дадлага хийх гэрээ байгуулж, танилцах дадлага, үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагад хамрагдсан 593 суралцагчид дадлагын тайлангаа амжилттай хамгаалсан. | 100 % |
| | | | 1.4.7 Мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх | Аймгийн төвийн 6 сургуулийн 9 дүгээр анги төгсөж байгаа 350 орчим сурагчийг хамруулсан. | Хамрагдсан хүний тоо: ЕБС-ийн 9, 12-р анги төгсөж байгаа сурагчид<br><br>Хамрагдалтын хувь: 80-100% | Мэргэжлийн боловсролын сургалтын өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлага, сургалтын үйл ажиллагаа явуулж буй байгууллагыг олон нийтэд сурталчлан таниулах, ерөнхий боловсролын сургуулиудын 9, 12 дугаар | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ангийн сурагчдад мэргэжил сонгох талаар мэдлэг олгох, мэргэжлийн боловсрол сургалтыг сурталчлах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд Сайншанд сумын ЕБС-ын 1, 2, 3, 5, 6-р сургууль, Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ, Чойр, Бор-Өндөр, Замын-Үүд сумын нийт 700 гаруй сурагчдыг хамруулсан уулзалт, өдөрлөг зохион байгуулж, 800 гаруй гарын авлага, тараах материалыг түгээлээ. | |
| **1.5.** | ***Байгууллагын хүний нөөцийн удирдлага, багшийн тасралтгүй хөгжлийг хангах, чадавхийг бэхжүүлэх, сургалтын байгууллагын менежментийг сайжруулах, хөгжүүлэх*** | | 1.5.1 Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчилж, 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу нийт 6 ажлыг 100% хийж гүйцэтгэсэн | Хэрэгжүүлсэн ажлын тоо: 5<br><br>Хэрэгжилтийн хувь: 100% | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг сургуулийн захирлын 2024 Б/5 тоот тушаалаар баталсан. Үүнд: багш ажилтнуудын ажиллах орчныг сайжруулах, сургалтын хэрэгцээг тодорхойлох, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг ахиулах, гүйцэтгэлд үнэлгээ хийж, ахицыг үнэлэх, ёс зүйн зөрчлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх, их дээд сургуулиудтай хамтран ажиллах олон талт арга хэмжээг хэрхэн зохион байгуулахыг тушаалын хавсралтуудад дурдаж | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байна. | |
| | | | 1.5.2 Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2024 төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | 2023 онд “Багшийн Хөгжлийн Хөтөлбөр”-ийн хүрээнд 3 зорилт, 8 ажил төлөвлөгдөж, 100% хэрэгжүүлсэн. | Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс дээш хувь хангасан байна. | Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн 5 ажлын 3-ийг Ажлын байр тохижуулах, хэрэглэгдэхүүнээр хангах, лаборатори анги (байгалийн шинжлэлийн) бий болгох ажлууд хийгдсэн.Нийт төсөвт өртөг: 19.0 сая төгрөг | 90% |
| | | | 1.5.3 Шинэ залуу багш, ажилтнуудын хөгжлийг хангах, идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх, тэдний ажлын байран дээрээ хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх | Анги удирдах урлаг цуврал сургалтанд 9 залуу багш хамрагдсан. | - Нийт 6 багш<br>- Хэрэгжилт 90-ээс дээш хувь | Анги удирдаж буй залуу багш нарт 3 цуврал хичээлийг, Судалгааны арга зүй, ХИЧЭЭЛ ХООРОНДЫН ИНТЕГРАЦИЙГ хэрхэн сайжруулах сэдвээр нийт багш нарт тус бүр 4 удаагийн сургалтыг ажлын байран дээр зохион байгуулсан. Үүний үр дүнд багш нарын дунд зохион байгуулсан хамтарсан хичээл, урилгатай хичээл арга хэмжээнд оролцогчдын тоо 20%-иар нэмэгдсэн. | 100 % |
| | | | 1.5.4 Багш тус бүр өөрийн хөгжлийн төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх | Багш нарын өөрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-тай үнэлсэн. | Хэрэгжилтийг 90-100% хангасан байна. | 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн багш бүр өөрийн хөгжлийн төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд батлуулж, гүйцэтгэлээ үнэлүүлж хэвшсэн. 2024 оны хичээлийн жилийн эцэст хийсэн Ахиц дэвшлийн тайлангийн хурлаар 11 багш өндөр үнэлгээ авсан амжилттай. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 8.9 | 1.5.5 Багшийн хөгжлийн төвийн орчинг шаардлагад нийцүүлэн сайжруулж, үйл ажиллагааг тогтмолжуулах | Хэрэгжилт 15%-тай байсан. | Хэрэгжилтийг 90-100% хангасан байна. | Багш хөгжлийн төвийн дотоод засал, цонхны битүүмжлэл, гэрэлтүүлэгт засвар шинэчлэлийн ажлыг хийж, зарим нэг тавилга эд хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн. Төсөвт өртөг: 8.9 сая төгрөг | 90% |
| | | | 1.5.6 Багш, ажилтны сургалтын хэрэгцээг тодорхойлж, тэднийг мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт, мэргэшүүлэх, түгээн дэлгэрүүлэх сургалтад хамруулах | Тайлант хугацаанд нийт 23 төрлийн сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 550 багш, ажилтан хамрагдсан. | Сургалтын тоо:<br><br>Хамрагдсан багшийн тоо: 25 | Багш, ажилтнаас эхний хагас жилийн байдлаар сэтгэл ханамжийн болон сургалтын хэрэгцээний судалгаа авч дүн шинжилгээ хийснээр 8 арга хэмжээ төлөвлөснөөс 4-ийг эхний 6 сард хийж гүйцэтгэсэн.<br>Багш нарын англи хэлний түвшин ахиулах сургалтыг Австралийн сайн дурын хөтөлбөрийн хамтын ажиллагаар 7 хоногт 2 удаа 4 цагийн англи багшийн цахим хичээлээр<br>Хүүхэд хамгаалал, эрсдэлт нөхцөл байдалд байгаа суралцагчид үнэлгээ хийх аргачлал сэдвээр 1 удаа<br>ХАБЭА-н ажилтан бэлтгэх сургалтанд 3 багшийг хамруулж гэрчилгээжүүлсэн<br>Камержуулалтын шинэчлэл хийх шаардлагатай байгаа талаар өгсөн саналыг үндэслэн 69.0 сая төгрөгийн төсвөөр 51 цэгт 72 дуу, дүрс хадгалж | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үлддэг нарийвчлал сайтай камерын шинэчлэлийг хийж гүйцэтгэсэн зэрэг болно. | |
| | | | 1.5.7 Багшийн мэргэжил, ур чадварын зэрэг дэвийг ахиулах ажлыг журмын дагуу зохион байгуулж, материал бүрдүүлэхэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | - 2022-2023 оны хичээлийн жилд тэргүүлэх шинээр 2 багш, заах аргач мэргэжлийн зэрэг шинээр 3 багшийн материалыг үнэлж, БЕГ хүргүүлсэн. | Зэргээ ахиулсан багшийн тоо: 5<br><br>Хамрагдалтын хувь: 10% | Багшийн мэргэжлийн зэрэг олгох журмын дагуу 5 багшийн материал хүлээн авч заах аргач зэрэг олгосон. | 100 % |
| | | | 1.5.8 Багшийн жилийн ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийж, ахицыг үнэлэх | Багшийн 2022-2023 оны хичээлийн жилийн ажлын үнэлгээнд 35 багш хамрагдаж, дунджаар 87,5% үнэлэгдсэн. | Үнэлгээний дүн, дундаж хувь: 85%-100% | 2024 хагас жилийн байдлаар 43 багш хамрагдаж дунджаар 85,2% тай үнэлэгдсэн. Ахицын тайлангийн хурлаар өмнө нь хангалттай үнэлэгдэж байгаагүй 7 багшийн үйл ажиллагааны үнэлгээ өссөн үзүүлэлттэй байна. | 85% |
| | | | 1.5.9 Багшийн ёс зүй, үнэлэмжийг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг 100% хэрэгжүүлсэн. | Хэрэгжүүлсэн ажлын тоо: 5<br><br>Хэрэгжилтийн хувь: 100% | 2024 оны 03 дугаар сарын А/41 тоот тушаалаар Багшийн ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд зөрчил дутагдал илрээгүй болно. | 100 % |
| | | | 1.5.10 Мэргэжлийн боловсрол сургалтын салбар, бусад ижил төстэй мэргэжлээр бэлтгэдэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллах | ОХ-ын Саха улсын мэргэжлийн боловсролын сургууль, Алс Дорнодын төмөр замын дээд сургууль, МБС-ын салбарын нийт 2 сургуультай хамтран ажилласан. | Хамтран ажилласан байгууллагын тоо: 4<br>Хэрэгжилтийн хувь: 100% | ӨМӨЗО-ны Бугат хотын Үйлчилгээний хамааралтай Жан Вен захиралтай ажил мэргэжлийн дээд сургуультай энэ оны 05 дугаар сард холбоо тогтоосноор тухайн сургуулийн удирдлагын багийн 7 хүн 2024 оны 06 дугаар сарын 28-30-ний | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрүүдэд манай сургууль дээр айлчилж хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар тохиролцоод байна. | |
| 1.6. | ***Суралцагч, төгсөгчдийн хандлага, төлөвшил, зан үйлийн харилцаанд эерэг өөрчлөлтийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах*** | | 1.6.1 Суралцагчийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжилтийг хангах (Хичээлээс гадуурх урлаг, спорт, бусад сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа) | Суралцагчийн хөгжил хамгааллын хөтөлбөрийн хүрээнд тайлант хугацаанд нийт 15 ажил төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлсэн. | Хэрэгжүүлсэн ажлын тоо: 10<br>Хэрэгжилтийн хувь: 100% | Гэр бүл хүүхэд залуучуудын газрын мэргэжилтэн Г.Энхтуяатай хамтран Хүүхдийн эрхийн хамгаалал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө мэдээллийг 165 суралцагчдад хүргэсэн.<br>Мөн сургуулийн эцэг эхийн зөвлөлөөр 9 гишүүн сонгон, суралцагсдын хүмүүжил, төлөвшил, хандлагыг өөрчлөх, нийгмийн харилцааны соёлын наад захын хэм хэмжүүрийг тэдэнд хэвшүүлэхэд хамтарч ажиллах, хүүхэддээ тавих хараа хяналтаа сайжруулах, суралцагсдын хөгжлийг дэмжих талаар санал солилцлоо. Нийт 89 эцэг эх асран хамгаалагч хамрагдсан.<br>Суралцагчдыг гэмт хэрэг зөрчил, үе тэнгийн дарамт хүчирхийлэл мөн хүмүүжлийн доголдол гаргасан 10 хүүхэд, эрсдэлтэй нөхцөлд байгаа 1 хүүхдийн ар гэр асран хамгаалагчидтай нь холбоо тогтоон уулзан хяналт тавин ажилласан | 65% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Суралцагчдын дунд зохион байгуулсан "Утаат тахал миний нүдээр" сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд 1-р байр ХГД 2а О.Цэцэг-эрдэнэ 2-р байр ХГД 1б Эрдэнэтунгалаг 3-р байр ХГД 1а Х.Мөнгөнсор нар шалгарсан.<br>ЭМГ-ын мэргэжилтэнтэй хамтран "Тамхины хор уршиг, "Охид, хөвгүүдийн өсвөр насны онцлог,эрүүл ахуй"сургалтыг 1-2 курсийн суралцагчдыг хамруулан зохион байгууллаа. Нийт 163 суралцагч хамрагдлаа.<br>Нийт 56 суралцагчдад ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>Электрон тамхины хор хөнөөлийн талаар 9 анги бүлэгт мэдээлэл хүргэсэн. Нийтдээ 156 суралцагч хамрагдсан. | |
| | | | 1.6.2 Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран суралцагчдад чиглэсэн нөлөөлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах | 7 удаагиийн сургалт арга хэмжээ зохион байгуулсан. | Хэрэгжүүлсэн ажлын тоо: 8<br>Хэрэгжилтийн хувь: 100% | "Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй", Хамтдаа сэргийлье" аянд нэгдэж мэдээллийг сургуулийн веб хуудсаар дамжуулан хүргэж ажилласан.<br>-Оюутны зөвлөлөөс санаачлан зохион байгуулсан" тамхинаас татгалзъя" аянд бүх анги хамт олон нэгдэж rell хийж бусдыг уриалж идэвхитэй оролцсон. | 50% |
| | | | 1.6.3 Дотуур байрны суралцагчдын харилцаа, | 11 арга хэмжээ хэрэгжүүлсэн | Хэрэгжүүлсэн ажлын тоо: 9 | Нийт 39 суралцагчдаас багш ажилчдын харилцаа | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвшил, хүмүүжилд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх | | Хэрэгжилтийн хувь: 100% | хандлага, дотуур байрны орчин нөхцөл, суралцагчдын харилцаа хандлагын талаар сэтгэл ханамжийн судалгааг 3 удаа авч ажилласан. Судалгааг нэгтгэн дүгнэлт хийж удирдлагад танилцуулсан. Судалгаанаас үзэхэд суралцагч хоорондын харилцаа хандлага дээр илүү анхаарах шаардлагатай байсан тул суралцагчдад 3 удаа харилцаа хандлага хүмүүжил төлөвшлийн талаар сургалтыг чөлөөт ярилцлага хэлбэрээр зохион байгуулсан. | |
| 1.7 | ***Батлагдсан төсөв, өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогыг үр ашигтай зарцуулах , багш ажилтан, суралцагчийн эрүүл аюулгүй таатай орчинд сурч хөгжих, ажиллах амьдрах нөхцлийг бүрдүүлэх*** | | 1.7.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын дагуу хуваарилагдсан төсвийг оновчтой хуваарилах, төлөвлөх, тайлагнах, хяналт тавих ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулах | - 2023 онд нийт 2,052,945,0 төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан.<br>- 2022 оны санхүүгийн аудитын зөвлөмжийн биелэлтийг 100 хувь биелүүлсэн. | Төсвийн хэмжээ: 3,858,169,7<br><br>Хэрэгжилтийн хувь:<br><br>Төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна. | 2024 онд нийт 3310,6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас Улсын төсвөөс: 3004,3 сая төгрөгийг, Орон нутгийн төсвөөс: 306,3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тус тус батлагдсан. Нийт төсвийн 74,3% буюу 2231,3 сая төгрөгийг цалин хөлс,ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд, 13,3% буюу 399,2 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх болон багш хөгжлийн зардалд, 2,7% буюу 77,5 сая төгрөгийг тэтгэвэр тэтгэмжийн зардалд, 1,9% буюу 58,9 сая төгрөгийг | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
